



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А62


Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулж, төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол улсын Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.4, 7.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2019 оны шинэ жилийн арга хэмжээ “Аз жаргалын-Мөнгөн үдэш” сүлд модны наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэг дүгээр хавсралтаар, төсвийн задаргааг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан 10170000 (арван сая нэг зуун далан мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий санхүүч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.
3. Аймгийн шинэ жилийн сүлд модны наадмын бэлтгэлийг ханган, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Баттогтох) -д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД